

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:**

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага

Албан тушаалтны нэр:

Эрүүлжүүлэх, saatuuulaah байрны
жижүүрийн цагдаа

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

Ажлын цаг:

12 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг гал түймэр хүн малын гоц
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй
байдал үүссэн, террорист халдлага, онц болон
дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг
үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд
өндержүүлсэн бэлэн байдалд ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго: Хууль тогтоомжийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хууль дээдлэх хүнлэг энэрэнгүй ёсыг эрхэмлэх, сотууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх, эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх, байрны дэглэм журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Албан тушаалын зорилт:

1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан "Саатуулах байрны дэглэм, журам"-ын хэрэгжилтийг хангаж, saatuuulagdsan болон эрүүлжүүлэгдсэн этгээдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн, цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандартын дагуу харилцаж, байгууллагын

Үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.

2. Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааг цагийн хуваарийн дагуу явуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, зааварчилгааны дагуу албан үүрэг гүйцэтгэх.

3. Цагдаагийн байгуулагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1 “Цагдаагийн албаны тухай хууль”, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан “Саатуулах байрны дэглэм, журам” Цагдаагийн байгуулагын үйл ажиллагааны Албадан саатуулах, Албадан эрүүлжүүлэх журмыг мөрдлөгө болгон саатууллагдсан эрүүлжүүлэгдсэн этгээдийг журмын дагуу хүлээн авч байрлуулан хяналт тавин ажиллана.</p> <p>1.2. Цагдаагийн байгуулагын үйлчилгээний стандартын дагуу харилцаж, байгуулагын үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.</p> <p>1.3. Эрүүлжүүлэх, саатуулах төвийн дотоод журмыг сахиулах, эрүүлжүүлэгдсэн хүмүүст хяналт тавьж байрны гадна болон дотор орчны аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p>	Цагдаагийн ажил үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх ажил эрчимжинэ.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргэгдэн ирсэн иргэдийн биед болон эд зүйлд үзлэг хийн хүлээн авч байрлуулан, байгуулагын дотоод журмын дагуу үйл ажиллагааг явуулна.</p> <p>2.2. Цагдаагийн байгуулагын үйлчилгээний стандартын дагуу харилцаж, үйлчлүүлэгчээс тавьсан санал, хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>2.3.Өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь нас, байгуулагын эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, таслан зогсоох, шаардлагатай тохиолдолд журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, тусгай мэх хэрэглэх, тусгаарлан байрлуулж, биечилсэн хяналтыг тавина.</p> <p>2.4. Анхаарал татсан хүмүүс болон өндөр настан, архаг архичин,</p>	Саатуулагдсан болон эрүүлжүүлэгдсэн этгээдийн эрхийг хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	Г Г Г, Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил		
Мэргэшил	Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах. Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах
	Асуудал шийдвэрлэх	Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог. Өөрийн үйл ажиллагааны үр дунд хяналт тавьж чаддаг.
	Багаар ажиллах	Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах. Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх.
	Бусад	Харилцааны үр чадвар эзэмшсэн байх, нөхцөл байдлыг зөв үнэлж шийдвэр гаргах чадвартай байх, багаар ажиллах чадвартай байх, тусгай хэрэгсэл, мэх зэвсэгтүйгээр бие хамгаалах чадварыг эзэмшсэн байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр: -Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах тасаг, хэсгийн дарга	
Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан, Шууд бус харилцах: Төрийн болон төрийн бус байгууллага, олон байгууллага, хуулийн этгээд, иргэн, /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛСАН:	АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ ХЯНАЖ, БАТЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T. ГАНЗОРИГ	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....

2023 оны 11 дугаар сарын 17-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-и өдөр.

Дугаар: 101

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-и өдөр



Танилцсан:

Танилцсан албан тушаалтан:

20... оны дугаар сарын-ны өдөр